

# БАЙНГА ОРШИН СУУХ ЭРХ - ЧЕХ ХЭЛНИЙ ШАЛГАЛТ

Хэрэв та БНЧУ-д байнга оршин суух зөвшөөрөл хүсэх гэж байгаа бол чех хэлний шалгалтыг А2 түвшинд өгөх шаардлагатай.

**АНХААР! ОРОГНОЛ, ШИЛЖИН СУУХ БОДЛОГЫН ГАЗАР (БНЧУ-ын Дотоод Хэргийн Яамны ОАМП) 2023 ОНЫ 8-Р САРЫН 31-НЭЭС ЭХЭЛЖ АНХ ШАЛГАЛТЫГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ӨГЧ БОЛДОГ БАЙСАН ЭРХИЙН БИЧГИЙГ ОЛГОХГҮЙ.**

Танд БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суух бодлогын газраас олгосон шалгалтын эрхийн бичиг байгаа юу?

- Та чех хэлний шалгалтын эхний оролдлогыг үнэ төлбөргүй өгөх боломжтой, гэхдээ эрхийн бичиг нь зөвхөн 2023 оныг дуустал хүчинтэй.
- Та хуанлийн жилд 3 удаа шалгалт өгөх боломжтой. 2023 оныг дуустал шалгалт өгөх оролдлого бүр 2500 крон.

2023 оны 10-р сараас шалгалтын байрыг нэмэгдүүлж, шинэ товгыг тасралтгүй гаргана. Дараах цахим хуудсыг дагана уу <https://cestina-pro-cizince.cz/>.

БНЧУ-ын Дотоод хэргийн яамны яамны Орогнол, шилжин суух бодлогын газраас олгосон шалгалтын эрхийн бичиг байхгүй юу?

- Чех хэлний шалгалтын төлбөрийг төлөх ёстой.
- 2023 оныг дуустал шалгалтын үнэ 2500 крон.
- 2024 оны 1-р сарын 1-нээс эхэлж шалгалтын үнэ 3200 крон.

Шалгалтад хэрхэн бүртгүүлэх вэ?

- Шалгалтыг [сонгосон сургуулиадад](#) өгч болно.
- Та [цахим өргөдлийн маягтаар](#) эсвэл сонгосон сургуульд өөрийн биеэр очиж бүртгүүлэх боломжтой.
- Бүртгэлийн үед та хүчинтэй паспорттой байх ёстой бөгөөд мөн шалгалтын өдөр шалгах болно.

Байнгын оршин суух эрхийн шалгалттай тэнцэх шалгалтууд нь:

- А2 болон түүнээс дээш түвшний ССЕ шалгалтууд (баталгаажсан шалгалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#))
- улсын хэлний шалгалт эсвэл элсэлтийн шалгалт
- иргэншил олгох зорилгоор чех хэлний шалгалт
- эмч, шүдний эмч, эм зүйч мэргэжлээр ажиллах мэргэжлийн ур чадвар олж авах, хүлээн зөвшөөрөх нөхцөлийг батлах шалгалт.

Та дэлгэрэнгүй мэдээлэл болон туршилтын тестийг эндээс авах боломжтой <https://cestina-pro-cizince.cz/trvaly-pobyt/a2/priprava-na-zkousku/>.



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

# БАЙНГА ОРШИН СУУХ ЭРХ - ЧЕХ ХЭЛНИЙ ШАЛГАЛТ

**Чех хэлний сайн мэдлэгтэй байх нь чухал, учир нь:**

- мэдээллийг илүү сайн ойлгох боломжийг олгоно,
- оршин суугаа нутгийн иргэдтэй харилцах харилцааг идэвхтэй мөн хөнгөвчлөх,
- олон нийтийн амьдралд оролцох оролцоог сайжруулдаг (оршин байгаа газартаа чиг баримжаа олох, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох),
- өөрийн эрх, үүргийн талаарх чиг баримжааг сайжруулах (орчуулагч болон бусад зуучлагч ашиглахгүйгээр).

**Чех хэлний А2 түвшний шалгалт нь аман болон бичгийн хэсгээс бүрдэнэ. Шалгалтын хоёр хэсэг нэг өдөр явагдана.**

1. Шалгалтын бичгийн хэсэг нь хоёр хэсгээс бүрдэнэ:
  - a. Тест - Унших болон бичих, ойролцоогоор 65 минут (дараа нь завсарлана)
  - Тест – сонсох, ойролцоогоор 35-40 минут

*Бичгийн шалгалтын хэсэгт шалгалт өгч буй хүн:*

- тогтоосон завсарлагааны цагаас гадуур шалгалтын байрнаас гарч болохгүй,
- аливаа электрон төхөөрөмж, ном, толь бичиг ашиглах, авч явахыг хориглоно,
- бие даан ажиллана,
- шалгалтын шийдлийг зөвхөн хариултын хуудсан дээр бичнэ, үүний тулд шалгалтын байгууллагаас өгсөн бичгийн хэрэгслийг ашиглана,
- хариултын хуудас болон асуултын хуудсыг зохих цагт нь өгнө.

2. Шалгалтын аман хэсэг нь (ойролцоогоор 15 минут) дараах хэсгээс бүрдэнэ:
  - a. асуултуудад хариулна
  - b. үзүүлсэн зургийг үндэслэн даалгаврын хариуг шийдэх

**Шалгалтыг амжилттай өгснийг нотлох баримт** нь шалгалтын байгууллагаас олгосон гэрчилгээ юм. Шалгалтад унасан хүн дахин шалгалтад өгөхдөө хоёр хэсгийг дахин өгнө. Нэг хуанлийн жилд шалгалт өгч байгаа хүн, дээд тал нь гурван удаа шалгалт өгч болно.



**Та туршилтын тестийг эндээс авах болно**

<https://cestina-pro-cizince.cz/trvaly-pobyt/a2/priprava-na-zkousku/>



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci